# Нэрт найрагч Х.Эрдэнэбаатар агсаны “Уулсын дуулал” цомгийн нээлт боллоо

Бичсэн turuu
2019 оны 4-р сарын 12, Баасан гариг, 15:48

МЗЭ-ийн эвлэлийн шагналт, Болор цомын эзэн, нэрт яруу найрагч Хоодоогийн Эрдэнэбаатар агсаны “Уулсын дуулал” яруу найргийн цомгийн нээлтэнд зориулсан хvндэтгэлийн vйл ажиллагаа энэ сарын 10-ны vдэш Ховд аймгийн Хогжимт драмын театрт болов.

Энэхvv vйл ажиллагаанд нэрт найрагч агсаны ойр дотны хvмvvс утга зохиолын болон уран бvтээлийн нохoд нь тvvний тухай дурсамж сэргээж, шvлэг зохиолоос нь уншиж, халуун яриа орнvvлж байснаас гадна шvлгэнд нь ая дан тааруулсан олон сайхан дуунуудыг мэргэжлийн дуучид уран бvтээлчид дуулан vзэгчдийн сонорыг мялаав.

Энэ vеэр Ховд аймгийн Засаг дарга, мон аймгийн Аудитын газрын дарга асан Л.Галбадрах Хоодоогийн Эрдэнэбаатар агсаны нэрээр нэрлэгдсэн сан байгуулагдсаныг мэдэгдэж, сангийн гэрчилгээ, тамга тэмдэгийг торсон охин Э.Янжинлхамд нь гардуулж огсон юм. Сангийн тэргvvн Э.Янжинлхам болоод vvсгэн байгуулагчид хэлэхдээ “энэхvv сангийн vйл ажиллагаа нь нутаг орондоо утга зохиол, яруу найргийг хогжvvлэхэд хувь нэмэр оруулж хамтран ажиллах, освор залуу найрагчид, уран бvтээлчдийг дэмжихэд чиглэгдэнэ” гэсэн юм.

Цомгийн нээлт хvндэтгэлийн vйл ажиллагаанд Монголын зохиолчдын эвлэлийн Ховд аймаг дахь “Алтай” салбарын удирдлага, хамт олон монхvv Ховд аймгийн Иргэдийн толоологчдийн хурлын дарга, Засаг даргын Тамгын газрын толоолол, найрагч агсаны торсон нутаг Дуут сумын удирдлага хамт олон, Жаргалант сумын удирдлага, хамт олон, аймгийн бусад байгууллага, газруудын толоолол, найз нохoд болон дэмжигч бусад хvмvvс хvндэтгэл vзvvлж, Х.Эрдэнэбаатар санд хандив оргосон юм.Â Â  Â Â Â